

Үзмэр цуглуулгын ажлын шинэ стандартууд

Шинэ түүхийн ач холбогдол

Салли Ваттерсон

Сеньор куратор ба захирал

Твеед Ривер орон нутгийн музей, Австрали

1. Үзмэр цуглуулах бодлого чухал болох нь
2. Цуглуулгын бодлого, хэрэгжүүлэх үе шатны тухай товч жишээ
3. Шинэ түүхийн үед хамаарагдах үзмэр цуглуулах, бүртгэх хадгалах талаар дэлхий дахины музейн чиг хандлага

“TWEED RIVER” орон нутаг судлах музей

Tweed River Regional Museum







1. Үзмэр цуглуулах бодлого чухал болох нь

1.1. Зорилго

Үзмэр цуглуулах бодлого нь:

- Музейн цуглуулга ямар байх талаар шийдвэр гаргах үйл явцыг зааж өгдөг.
- Үзмэр цуглуулах, зээлүүлэх ба хасах ажлыг зохион байгуулах цогц зарчим юм
- Цуглуулга мэргэжлийн дадлага туршлага ба тогтсон журмын дагуу ашиглагдана
- Цуглуулгын бодлого ОУМЗ-ийн Ёс зүйн дүрэмд хир нийцэж буйг 5-н жил тутам хянаж байна.

2.1.Ерөнхий зарчмууд

- Үзмэр цуглуулах ажил, түүний менежментийг ОУМЗ-ийн Ёс зүйн дүрэм ба тухайн улсын хөдлөх өвийн байгууллагаас гаргасан хууль дүрмийн дагуу явуулна.
- Цуглуулгын бодлого нь бусад музей, галарей, номын сан, эд өлгийн зүйл хадгалдаг газар, архив ба өвийн газруудын бодлоготой уялдаатай байна.
- Цуглуулга музейн чиглэлд тохирохгүй нөхцөлд үзмэр цуглуулгаас өөр үйл ажиллагааг идэвхтэй явуулна.
- Соёлын өвийн чухал дурсгалт газар ба түүхэн барилгын ач холбогдлыг бууруулахаар бол дурсгал болон эд өлгийн зүйл эрсдэлд байгаагаас бусад тохиолдолд, тэдгээрийг авч болохгүй
- Эд өлгийн зүйлийг хандив, өв залгамжлал, худалдан авах буюу шилжүүлгээр цуглуулж болно.

2.2. Үзмэр цуглуулах зарчмууд

Твеед ривер мужийн түүхэнд чухал ач холбогдолтой, түүний онцлогийг тусган харуулж чадах хүмүүс, газар нутаг ба үйл явдалтай холбоотой, дараах шалгуурыг хангах эд өлгийн зүйлүүдийг музейд авах эсэхийг авч үзнэ. Үүнд:

- Гурван хэмжээст эд өлгийн зүйл
- Баримт бичиг ба хэвлэл ном
- Урлагийн эх бүтээл
- Эх гэрэл зураг
- Сийлбэр
- Гэнэтийн үйл явдлын тухай кино, бичлэг
- Чанартай цахим материал ба дүрс бичлэг

2.Цуглуулгын бодлого, хэрэгжүүлэх үе шатны тухай товч жишээ

2.3. Үзмэр цуглуулгын шалгуур

Шалгуур 1. Түүхэн ач холбогдолтой

Тус мужийн 6-н гол түүхэн үе шатны аль нэг үе шатанд үүссэн байх. Үүнд:

- 1844 он хүртэлх колонийн үе
- 1844-1900 он хүртэлх хот, суурин хөгжсөн үе
- 1901-1945 оны дайны дараа үүссэн холбооны үе
- Дайны дараах 1946-1980 оны шилжилтийн үе
- Эрэг рүү нүүсэн үе, 1980 оноос хойш

Шалгуур 2. Сэдэвтэй байх

- Байгаль орчны: геологи, газар зүй, цаг уур, байр зүйн
- Үйлдвэр, үйлчилгээ: хөдөө аж ахуй, хөдөөгийн амьдрал, ойн аж ахуй, аялал жуулчлал, загас агнуур
- Хүмүүс, үйл явдал, чөлөөт цаг, спорт, шашин ба соёл
- Уугуул хүн амын түүх
- Өмнөд далайн арлын түүх
- Далай болон голын эрэг орчмын түүх
- Хүүхэд эмэгтэйчүүдийн түүх

Өвийн цуглуулгын зөвлөлөөс гаргасан арга зүй ба шалгуурын хүрээнд нь үнэлгээг хийдэг

Үнэлгээний анхны шалгуур нь:

- Түүхэн ач холбогдол
- Гоо зүйн ач холбогдол
- Шинжлэх ухааны ач холбогдол
- Нийгмийн болон оюуны ертөнцийн ач холбогдол

Харьцуулалтын шалгуур нь

- Гарал үүсэл
- Төлөөлөх чадвар
- Ховор эсэх
- Хадгалалтын байдал, бүрэн бүтэн байдал, гэмтэлгүй
- Тайлбарлах чадвар

2.4. Үзмэрийг хасах зарчмууд

Үзмэрийг хасах нь тодорхой шалтгаанаар эд өлгийн зүйлийг цуглуулгын бүртгэлээс гаргаж, батлагдсан бодлогын дагуу бүрмөсөн хасах үйл явц юм.

2.5. Хасах шалгуур нь:

- Цуглуулгын бодлого ба үзмэр олж авах шалгууртай нийцэхгүй буюу бага зэрэг нийцэх
- Муу хадгалагдсан ба гарал үүсэл нь тодорхойгүй ба баримт бичиг байхгүй
- Музейн цуглуулга ба бусад хамааралтай цуглуулгын хуулбар
- Аюулгүй хадгалж, хамгаалах болон зохион байгуулах боломжгүй
- Илүү ач холбогдолтой үзмэр нь өмнө олж авсан адил үзмэрийг хэрэггүй болгох

Онцгой тохиолдолд эд өлгийн зүйл тодорхой уугуул хүн амын соёлыг илэрхийлэх ач холбогдолтой бол хүн амд нь буцаахыг дэмждэг.

3.1. Үзмэр цуглуулах ажлын үе шат, дэс дараалал

- Үзмэр цуглуулах ажлыг хийж эхлэх ажилтан бол ахлах куратор юм.
- Музейд үзмэр хандивлах хүнийг Хандивын өргөдөл бөглөхийг хүснэ.
- Музейн ахлах куратор эд өлгийн зүйлд үнэлгээ хийх, авч хэлэлцэхийг зөвшөөрсөн тохиолдолд Үзмэр хүлээж авах завсрын актыг хийнэ.
- Музейн ахлах куратор эд өлгийн зүйл цуглуулгад тохирох эсэхийг Цуглуулгын шалгуурын дагуу үнэлнэ. Тэрээр холбогдох шинжээчдийн зөвлөлгөөг авч болно.
- Музейн ахлах кураторын санал дээр үндэслэн Музейн зөвлөх хороо хандивын өргөдлийг хүлээн авах буюу хүлээж авахгүй буцаана.

- Хандивлагчийг Бэлэглэлийн маягтад гарын үсэг зурахыг хүсэх бөгөөд энэ маягт нь музейд эд өлгийн зүйлийг өмчлөх хууль ёсны эрхийг шилжүүлнэ.
- Хандивлагчид Талархлын захиа өгнө
- Эд өлгийн зүйлийг Эд өлгийн зүйлийг музейд авсан тухай бүртгэлийн дэвтэрт бүртгэх бөгөөд музейд авсан дугаарыг өгнө.
- Эд өлгийн зүйлийг дугаарлаж, гэрэл зургийг авч, каталогт оруулах ба түүнтэй холбогдолтой мэдээллийг Эд өлгийн зүйлийн хавтаст хоёр хэлбэрээр цуглуулна. Үүнд: цаасаар болон Музейн цуглуулгын цахим санд

3. Шинэ түүхийг музейд тусгах талаарх олон улсын чиг хандлага

- 20 боло 21 дүгээр зуун бидэнд ойр хэдий ч хэрэглэгчийн өнөөгийн нийгэмд түргэн алга болж байна.
- Шинэ түүх уйтгартай буюу хэцүү мэт санагдах нь олонтоо
- Шинэ бүтээгдэхүүний техникийг эд өлгийн зүйл/өв гэж үзэхэд илүү эмзэг байх бөгөөд тэдгээр нь богино настай байдаг
- Шинэ мэдээллийн хэрэгслийн хувьд юуг яаж цуглуулах вэ?
- Шинэ технологийг яаж цуглуулгад хамрах вэ?

sallywatterson@yahoo.com